

АГУУЛГА

1. 2025 ОНЫ ДОЖИР ОРДЫН АШИГЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны харьяалал	2
1.2 Баяжуулах үйлдвэрийн дэд бүтэц, барилга байгууламжууд:	3
1.3 Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа:	6
1.4 “Ханшашир” ХХК-ийн Байгаль орчны үнэлгээ, холбогдох зөвшөөрлүүд:	6
2. ДОЖИР ДАЛД УУРХАЙН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН	8
НИЙТ ЗАРДАЛ	8
3.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	8
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:	8
Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	10
Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	11
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:	12
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	13
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
5.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ	15
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ	15
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН	20
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
11. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
12. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	26


1. 2025 ОНЫ ДОЖИР ОРДЫН АШИГЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны харъяалал

Төслийн харъяаллын байршил: Дожир уурхай болон Баяжуулах үйлдвэр нь Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Наран багийн нутаг дэвсгэрт харьяалагддаг бөгөөд Улаанбаатар хотоос зүүн зүгт 420 км, Хэнтий аймгийн төвөөс зүүн зүгт 150 км, Баян-Овоо сумын төвөөс баруун зүгт 25 км-т байрладаг.



Зураг 1. Дожир уурхайн байршил



Зураг 2. Уурхай болон баяжуулах үйлдвэрийн байрзүйн зураг (1.Хаягдлын сан, 2. Баяжуулах үйлдвэр, 3. Ажилчдын кемп, 4-6. Уурхайн ам, 7. Ажилчдын кемп, 8. Хяналтын пост)

Жонш баяжуулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл:

Хүснэгт 1. Ханиашир ХХК-ийн мэдээлэл

ААНэгжийн нэр	Улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн хаяг, байршил
“Ханиашир” ХХК	9019058081	-Ашигт малтмал ашиглалт -Гадаад худалдаа -Ашигт малтмалын хайгуул хийх	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 3 Оргил хотхон 62-1 тоот

Хүснэгт 2. Ханиашир ХХК-ийн холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл

№	Овог, нэр	Албан тушаалын нэр
1	Li Zhihui	Гүйцэтгэх захирал
2	Эрдэнэбилэг	Уурхайн дарга
3	Мягмарсүрэн	ХАБЭА-ны инженер
4	А.Лхагвасүрэн	Ерөнхий инженер
5	Солонго	Баяжуулагч инженер
6	Наран-Эрдэнэ	Геологич
7	Х.Гэрэлмаа	БОМэргэжилтэн

1.2 Баяжуулах үйлдвэрийн дэд бүтэц, барилга байгууламжууд:


Дожир жоншны далд уурхай болон баяжуулах үйлдвэрийг ашиглах төлөвлөгөө, Техник эдийн засгийн үндэслэл болон бусад бичиг баримтуудад уурхай болон баяжуулах үйлдвэрийн гол барилга, байгууламжууд нь MV-016819 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байрлаж байхаар тусгасан байна.





Зураг 3. Уурхайн баяжуулах үйлдвэр, ажилчдын кемп

ОО болон угаалгын газар: Ажилчдын кэмийн урд талд стандартын шаардлага хангахуйц доторлогоотой /хагас нэвчилттэй/, агааржуулалтын хоолойтой 3 ш нүхэн жорлон, ажилчдын амрах байран дотор ОО болон халуун ус, угаалгын газрыг байгуулан ашиглаж байна.



Зураг 4. ОО



Зураг 5. Угаалгын өрөө

Хаягдлын сан: Баяжуулах үйлдвэр нь нийт ажиллах хугацаандаа 199757.6 тн хүдэр баяжуулах ба хаягдлын санд 122884.46 тн 45512.76 м³ хаягдал хаягдана. Жилд 11392 м³ 2-р шатны хяналтын флотацийн хаягдал хаягдлын санд орохоор эзлэхүүнийг тооцоолсон ба далангийн өндөр 5-8 м байна. Тус үйлдвэрийн хаягдал агуулах сан нь булинга хуримтлуулах 1 ба 2-р сан болон эргэлтийн усан сангуудаас бүрдэнэ. Булинга хуримтлуулах 1-р сангийн ус шүүрүүлэх хэсгээр усыг цэвэршүүлэн хуримтлуулах 2-р цөөрөмд шилжүүлж тэндээс эргэлтийн усны цөөрөмд ус хуримтлагдана. Ингэснээр хаягдлын санд цөөрөм үүсгэх усны хэмжээг бууруулна. Жилийн ихэнх хугацаанд ус дахин ашиглах цөөрөмд орж баяжуулах үйлдвэрийн дэргэдэх усны цөөрөмд шилжиж орно. Хаягдлыг өөрийн урсгалаар нь сан хүртэл тээвэрлэж, дараа нь хаях цэгүүдэд насосоор шахна. Хаягдлын аж ахуй нь баяжуулах үйлдвэрээс 0.2 км зайд оршино.



Зураг 6. Хаягдлын байгууламж

Цахилгаан хангамж: Цахилгаан эрчим хүчний хэрэгцээг Батноров 35/10 кВ дэд станцаас салбарлуулан 31 км агаарын шугам татаж, шугамын төгсгөлд 10/0.4 кВ-ын дэд өртөө угсран угсран ашиглалтанд оруулсан.



Зураг 7. Баяжуулах үйлдвэрийн дэд станц

Усан хангамж: Ажилчдын унд ахуй, баяжуулах үйлдвэр болон нөхөн сэргээлтэд ашиглах усыг тус “Ханшашир” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайн баруун урд хэсэгт байрлах өөрийн эзэмшлийн гүн өрмийн худгаас (Худгийн байршил /111°47'13" 47°44'16" ундрага 6.5 л/сек) авч ашиглаж байна. Унд ахуй, баяжуулах үйлдвэр болон нөхөн сэргээлтэд болон шаардлагатай тохиолдолд зам усалгаанд ус хэрэглэхээр тооцсон. Баяжуулах үйлдвэрийн нийт хэрэгцээт усны 80.0 %-ийг эргэлтийн усан хангамжаар шийдвэрлэх бөгөөд үлдсэн 20.0 %-ийг цэвэр усаар хангахаар ТЭЗҮ-д тооцоолсон. Баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн хэсэг нь уурхайн гүний усны шавхалтын шугам хоолой, технологийн усны шугам хоолой, тоног төхөөрөмжийн хөргөлтийн усны шугам хоолой, тоос дарах болон бусад шаардлагатай усны шугам хоолой, аваарын усны сан, даралтын насос зэргээс бүрдэнэ. Уурхайн гүний шавхалтын шугам хоолойн ус дамжуулах насосны станцын гарах аманд урсацын хэмжээ, даралтыг шалгах хэмжүүр суурилуулсан. Үйлдвэрийн төв байшин доторх баяжуулах ба бусад дамжлагад мөн дээрх хэмжих багажийг тохируулж хяналтын өрөөнөөс системийн ажлын байдал болон усны зарцуулалтад хяналт тавьж байна. Баяжуулах үйлдвэрийн хажууд цэвэр усны 1 ш, эргэлтийн усны 2 ш усан сан байрлуулан, гүний худгаас ирэх цэвэр усыг үйлдвэрийн цэвэр усны $2.60 \times 9.50 = 50 \text{ м}^3$ багтаамжтай усан санд хуримтлуулан усны хэрэгцээг хангаж байна. Тус уурхайн усны хэрэглээ нь унд ахуйн хэрэглээ, баяжуулах үйлдвэрийн технологийн ус хэрэглээнээс бүрдэнэ.

2024 онд баяжуулах үйлдвэрт 9651.0м³, ногоон байгууламжийн усалгаанд 552.0м³, унд ахуйн хэрэглээнд 969.0м³, зам усалгаанд 28.8 м³ нийтдээ тайлангийн хугацаанд 11200.8м³ ус хэрэглэсэн байна.



Зураг 8. Баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн шугам хоолой

1.3 Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа:

“Ханшашир” ХХК-ийн жоншны баяжуулах үйлдвэр нь жоншны хүдрийн физик хими шинж буюу эрдсийн гадаргуу усанд “норох ба үл норох” чанарт үндэслэгдсэн флотацийн аргаар баяжуулагдана. Энэ технологи нь нарийн нунтаглагдсан хүдрийг урвалжийн тусламжтайгаар хөөсрүүлэлт үүсгэн ашигт эрдсийг хөөсөнд наалдуулан ялган авч хоосон чулуулгийг машины камерт үлдээж ялгах зарчимд тулгуурлана. Баяжуулах үйлдвэр нь ашиглалтын лицензтэй, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй талбайгаасаа хүдрээ хангана. Буталсан хүдэр бункерээс туузан дамжуулагчаар бөмбөлөгт тээрэмд орж, 65-85% нь 200 меш болтол нунтаглагдсаны дараа хөвүүлэн баяжуулалтад орно. Жоншны хүдэр баяжуулах технологид техникийн сод, шингэн шил, олеат натри, нарсны тос зэрэг урвалжуудыг ашиглана.

Тус жоншны баяжуулах үйлдвэрт жилд 38.58% дундаж агуулгатай 50000 тн жоншны хүдрийг флотацийн баяжуулалтаар 95.77%-ийн агуулгатай 21800 тн баяжмал авч 4.7%-ийн агуулгатай 28200 тн хаягдал ялгана.

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь дараах шат дамжлагуудаас бүрдэнэ.

Үүнд: Хүдэр баяжуулалтад бэлтгэх хэсэг

Нунтаглан баяжуулах хэсэг

Урвалжийн хэсэг

Шүүн хатаах, савлах хэсэг зэрэг технологийн үндсэн шат дамжлагуудаас бүрдэнэ.

Баяжуулах үйлдвэр нь жилд хавар 6 сарын 1-ээс өвөл 10 сарын 17 хүртэл тасралтгүй 137 хоног ажиллах бөгөөд 2 ээлж 12 цагаар ажиллана. Бусад үед нь засвар үйлчилгээ хийнэ.

1.4 “Ханшашир” ХХК-ийн Байгаль орчны үнэлгээ, холбогдох зөвшөөрлүүд:

1.4.1 Компанийн эзэмшдэг тусгай зөвшөөрлүүд:

Хүснэгт 3. Компанийн эзэмшдэг тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Дугаар	Хүчинтэй хугацаа
1	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл	MV-016819	2014.11.25-2041.04.28

1.4.2 Байгаль орчны холбогдох зөвшөөрөл

Хүснэгт 4. Холбогдох зөвшөөрлүүд

№	Зөвшөөрлийн зориулалт	Дугаар	Хүчинтэй хугацаа
1	Химийн хорт болон аюултай бодис ашиглах	0002388	2023.03.09-2027.12.31
2	Усны боломжит нөөцийн дүгнэлт	65	2021.05.13
3	Ус ашиглах зөвшөөрөл	A/12	2024.07.24
4	Ус ашиглуулах дүгнэлт	E-2405-000025	2024.06.18
5	Хаягдал усны дүгнэлт	114	2023.09.25
6	Химийн бодисын агуулахын дүгнэлт	22-04-017/112	2022.09.16
7	Галын аюулгүй байдлын дүгнэлт	0011766	2025.05.22
		0011786	2025.06.02
		0004365	2026.05.22
		0011792	2025.06.02

1.4.3 Газар ашиглалтын зөвшөөрөл

Хүснэгт 5. Газар ашиглах зөвшөөрлүүд

№	Газар эзэмших зориулалт	Гэрчилгээний дугаар	Газрын хэмжээ /га/	Хүчинтэй хугацаа
1	Ашиглалт олборлолт явуулж буй уурхайн талбай	000001734	98.37	2025.06.15

1.4.4 Байгаль орчны үнэлгээ

Хүснэгт 6. БОННУ-ний тайлангууд

№	БОННУ тайлангийн нэр	Батлагдсан он
1	Хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн төслийн БОННУ-ний тайлан	2021

2. ДОЖИР ДАЛД УУРХАЙН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ

Дожир далд уурхайн MV-016819 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж буй үндсэн олборлолт, хүдэр баяжуулалтын үйл ажиллагаа нь тогтсон хугацаанд хэвийн явагдсан бөгөөд компани өөрийн дотоод нөөц бололцоогоо ашиглан дүйцүүлэн хамгааллын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төлөвлөгдсөн газруудад мод тарьж, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба 2025 онд хэрэгжүүлэх БОМТөлөвлөгөөг БОАЖ-ын ямаар батлуулан ажиллаа. Тус уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал зэргээс бүрдэх бөгөөд мөн дүйцүүлэн хамгаалал болон төсөл хэрэгжиж буй орон нутгийн захиргааны байгууллагаас санал болгосон ажлын зардалд нийтдээ **34,269,280.00** /Гучих дөрвөн сая хоёр зуун жаран есөн мянга хоёр зуун наян төгрөг/-ийг төсөвлөснөөс **55,622,248.00 төгрөг** зарцуулсан байна.

БОМТ-ний тайлангийн задаргаа

№	Зардлын төрөл	Дүн (төгрөг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлын биелэлт	19,536,248.00
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	0
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт	10,370,500.00
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
6	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	3,916,000.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	3,280,000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	3,017,000.0
9	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	15,502,500.0
10	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
	Нийт дүн	55,622,248.0

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1: Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
1	Үйлдвэрлэл, төслийн үйл ажиллагааны үед ашиглах тээврийн хэрэгсэл зэргээс агаар	Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хязгаарлах, тодорхой маршрутаар явуулах	-	Хүнд даацын автомашины тээвэрлэлт хийх дотоод замын маршрутыг нэг урсгалаар зохион байгуулж, орох, гарах чиглэлийг тогтоон тусгаарлаж, хүдрийн овоолгын зам, баяжмал зөөх зам гэсэн чиглэлээр дотоод тээвэрлэлтийн замын маршрутыг Уурхайн даргаар батлуулан тээвэрлэлтийг

	орчинд үүсэх	тоосжилт		зохион байгуулж байна. Мөн жолооч нарт олон салаа зам гаргахгүй байх талаар ХАБЭА-ны ажилтан тээвэрлэлт хийх бүрт зөвөлгөө өгч ажиллаж байна. <i>/Хавсралт зураг 3.1-1/</i>
2		Дуу чимээ бага гаргадаг техникийн үзүүлэлт сайтай тоног төхөөрөмж сонгох, суурилуулалтын ажлыг сайн хийх	-	Баяжуулах үйлдвэрт ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүд нь Баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-д тусгагдсан шаардлагыг хангасан тоног төхөөрөмжүүдийг суурьлуулсан бөгөөд дуу чимээний хэмжилт хийхэд / Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл мэнд. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000, хүлцэх хэмжээ 85 дБА/ дунджаар дээд хэмжээ 82 дБА байна. <i>/Хавсралт зураг 3.1-2/</i>
3		Орчны тоосжилт болон салхины хурд дуу чимээг бууруулах зорилгоор мод сөөг тарих	Баяжуулах үйлдвэрийн ногоон байгууламжийн талбайд мод бут тарих	2025 онд Баяжуулах үйлдвэрийн орчны тоосжилт, дуу чимээг бууруулах зорилгоор 500 ш хайлаас намар 10-р сарын 11-15-ны хооронд Баян-Овоо сумын Наран багийн “Талын хөндлөн” байгалийн нөөцийг хамгаалах нөхөрлөлтэй гэрээ байгуулан ажиллаж, модны тээвэрлэлтэд 360000 төгрөг, тарьц суулгацын үнэ 3500000 төгрөг, ажлын хөлсөнд 2760000 төгрөг , нийт 8 иргэн ажиллаж, 6620000 төгрөг зарцуулсан. <i>/Хавсралт зураг 3.1-3/</i>
4		Тээврийн хэрэгсэлийн засвар үйлчилгээг байнга хийж тээврийн хэрэгслээс гарах утааны хэмжээг стандартын хэмжээнд байлгах	2 удаа	Баяжуулах үйлдвэр нь машин, механизмын хөдөлгүүрийн тохиргоо, засвар үйлчилгээг хаврын улиралд ажил эхлэхийн өмнө хийж гүйцэтгэдэг бөгөөд эвдрэл гарахаас урьдчилан сэргийлэн автомашины тойрох үзлэгийг ажилд гарахын өмнө тогтмол хийж хэвшсэн. 2025 онд компанийн нийт 5 авто техник Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн улсын үзлэгт бүрэн хамрагдаж тэнцсэн үнэлгээ авсан. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хураамжид нийт 143000 төгрөг төсөвт төвлөрүүлсэн. Мөн агаар бохирдуулсны төлбөр нийт 5 автомашин, 36500 төгрөгийн төлбөрийг бүрэн барагдуулсан. Нийт 179500 төгрөг зарцуулсан. Хүнд даацын автомашины хөдөлгүүрийн тохиргоо, их засвар үйлчилгээг тогтсон хугацаанд 2 удаа хийж гүйцэтгэн ХАБЭА-ын ажилтан өдөр тутмын хяналт тавин ажиллаж байна.
5		Ажилчдыг тоосноос хамгаалах нэг бүрийн хэрэгслээр хангах	200ш	Баяжуулах үйлдвэрийн ажилчдын ажлын байрны онцлогоос шалтгаалан нэг удаагийн маск болон фильтр сольдог маск зэрэг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр ханган ажиллаж байна. Нэг бүрийн хамгаалах хэрэгсэлд нийт 2,560,000.0 төгрөг зарцуулсан. <i>/Хавсралт зураг 3.1-5/</i>

6	Төслийн хог хаягдлын цэгээс ялгарах үнэр, тоос шороо, утааны бохирдол нь агаар орчинд сөрөг нөлөө үзүүлнэ.	Төслийн талбайд байгуулагдах нэгдсэн хогийн цэгийг стандартын дагуу тохижуулах	1 удаа	Баяжуулах үйлдвэрийн хог хаягдал хадгалах түр цэгийг хог хаягдал хийсэж орчноо бохирдуулах, хөрсөнд нэвчихээс сэргийлж хадгалах талбайг цементлэн, хашаа хаалт хийн, тэмдэг, тэмдэглэгээ хийж, хадгалж байна. <i>/Хавсралт зураг 3.1-6/</i>
7		Ажилчдын амралтын өрөө, тасалгаануудад тогтмол чийгтэй цэвэрлэгээ хийлгэж, тоос үүсэхээс урьдчилан сэргийлэх	-	Үйлчилгээний ажилчин 1 ээлжинд 1 ажилтан ажилладаг бөгөөд ажилчдын амрах байр, офиссын өрөө, угаалгын өрөөнүүдэд өдөр бүр чийгтэй цэвэрлэгээ хийдэг бөгөөд ээлж солилцохын өмнө өрөө тасалгаануудад их цэвэрлэгээ хийж ажлаа хүлээлцэж хэвшсэн. Мөн ажилчдын ажлын хувцсыг цагийн хуваарийн дагуу угаах ажлыг хийж гүйцэтгэдэг. <i>/Хавсралт зураг 3.1-7/</i>

3.2.:Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
1	Унд ахуй болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг их хэмжээгээр ашиглан усан орчинд сөрөг нөлөө үзүүлэх	Баяжуулах үйлдвэрт усыг дахин ашиглахдаа технологийн горимыг алдагдуулахгүйгээр ашиглах	-	Баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу Уурхайн шавхалтын усны шугамнаас баяжуулах үйлдвэрийн усан санд хуримтлагдсан ус болон үйлдвэрийн хаягдлын санд хуримтлагдсан эргэлтийн усыг дахин ашиглах технологийн дагуу усыг 100% дахин ашигласан бөгөөд ус ашиглалтын явцад Баян-Овоо сумын Татварын улсын байцаагч, ЗДТГ-ын Байгаль орчны мэргэжилтэн сар бүр хяналт тавьж ажилласан. Үйлдвэрийн технологийн горим алдагдах нөхцөл байдал үүсээгүй болно. <i>/Хавсралт зураг 3.2-1/</i>
2		Усны зөв зохистой хэрэглээг хангаж ажиллах, усны хэрэглээнд хяналт тавих, тоолууржуулах	1ш	2025 онд Баяжуулах үйлдвэр нь технологит цэвэр ус ашиглаагүй бөгөөд үйлдвэрийн ажилчдын унд ахуйн хэрэглээнд цэвэр ус ашигласан ба сумын Татварын улсын байцаагч, Байгаль орчны мэргэжилтэн нар усны тоолуурын заалтыг баталгаажуулан бүртгэл хийж, ахуйн хэрэглээнд ус ашигласны төлбөрийг тооцож ажилласан. Унд ахуйн худгийн тоолуурын гэрчилгээ №2310099901, 2025 оны байдлаар нийт төлбөр 771000 төгрөг төлсөн. <i>/Хавсралт зураг 3.2-2/</i>
3		Усны эх үүсвэрийн энгийн хамгаалалтын бүсийг байнгын харуул хамгаалалттай байлгах	1 удаа	2015 оны А-230/127-р тушаалаар батлагдсан Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.8-д заасны дагуу ус хангамжийн эх үүсвэрийг гадны бохирдлоос хамгаалж 3х3 харьцаатай барилга барьж, худгийн цооногийн орчныг болон барилгын хаяавчийн эргэн тойрныг цементэлж битүүмжлэн хамгаалсан. Мөн худгийн цооногийн хоолойг битүүмжилж, бохирдохоос бүрэн хамгаалсан. 24 цагийн харуул хамгаалалт ажиллуулж, цооногийн бүрэн бүтэн байдлыг хянах, ус түгээх үед зөвшөөрөлгүй хүн оруулахгүй байх санамж зэргийг өгч ажиллаж байна. Гүний худаг нь

				байгалийн гэрэлтүүлэгтэй бөгөөд цахилгаан эх үүсвэрт холбогдож усаа түгээдэг. /Хавсралт зураг 3.2-3/
4		Зам усалгааг цаг агаарын мэдээнд уялдуулж услах	1 удаа	Уурхайн 1, 2, 3-р амнаас баяжуулах үйлдвэрийн хүдэр буулгах талбай хүртэл замын сул шороог салхинд хийсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тоосжилт дарах усалгааг, хуурайшилт ихтэй үед 7 хоногт 1 удаа, үйл ажиллагааны туршид 4 удаагийн усалгаа хийсэн.

3.3:Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
1	Үйлдвэрийн болон ахуйн хэрэглээнээс гарах хатуу шингэн хаягдлын улмаас хөрс бохирдох, эвдрэлд орох	Ажилчдын суурин дахь захиргаа үйлчилгээний ажилчдын зорчих явган хүний зам талбайг зориулалтын хайрган хучилттай болгох	1 удаа	Баяжуулах үйлдвэрийн ажилчдын кемпийн явган хүн зорчих хэсгийн замыг хайрга асган хучиж тэгшлэн засаж сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг ажилд 2 автомашин, 4 ажилчид оролцож, шатахуунд 316000 төгрөг зарцуулсан. /Хавсралт зураг 3.3-1/
2		Ахуйн хэрэглээнээс гарч байгаа хаягдлыг зориулалтын тагтай саванд хаях	-	Баяжуулах үйлдвэрийн ажилчдын ахуйн бохирын цооногийг хагас нэвчилттэй доторлогоотой байгуулсан бөгөөд орчинд үнэр тархахаас сэргийлж байнгын тагтай байлгаж, орчны бохирдол үүсгэхгүй байх, үүссэн бохирдлыг цэвэрлэх, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг үйлчлэгч, тогооч нар хариуцан хийж гүйцэтгэж байна. Ариутгал, халдваргүйтгэлийг сард 2 удаа, нийт 6 удаа хийсэн.
3	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр хөрс эвдрэл, бохирдолд орох	Баяжуулах үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж болон авто тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний талбайг тос, тосолгооны материал асгарч хөрсөнд нэвчихээс сэргийлэн шалыг цементлэх	1 удаа	Баяжуулах үйлдвэрт ашиглагдаж буй өөрөө буулгагч автомашин болон бусад тээврийн машинуудын засвар үйлчилгээг зориулалтын газар хийж, засварын цехийн талбайг цементлэн орчны бохирдлоос сэргийлэн ажиллаж байна. Цементэлсэн талбай 5х6 30м² , нийт 162000 төгрөг зарцуулав.
4		Хаягдлын далангийн бүрэн бүтэн байдлыг хянаж, тухай бүрт нь засварлаж байх	1 удаа	Хаягдлын далангийн бүрэн бүтэн байдалд Баяжуулагч инженер болон туслах ажилчид 4 удаа хяналт тавьж, сан халих, шүүрэлт үүсэх нөхцөл байдал үүсээгүй хэвийн байна. /Хавсралт зураг 3.3-4/
5	Үйл ажиллагаанаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох	Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглах	-	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу Баяжуулагч инженер хариуцан, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг өдөр бүр хянаж, засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн осол авааргүй ажилласан.

6		Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлтийг хангах үүнд ИТА-д хяналт тавих, хариуцан ажиллах	-	Баяжуулах үйлдвэр, хаягдлын сан нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дотор байрлах бөгөөд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар ашиглах гэрчилгээ авч үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулж байна. <i>/Хавсралт зураг 3.3-6/</i>
---	--	---	---	---

3.4: Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
1	Ургамлан нөмрөг доройтсоноор идэш тэжээлийн хомсдол үүсэх	Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын хэмжээг бууруулах, ургамлыг хөлөөр болон тээврийн хэрэгслээр олон салаа зам гаргаж талхлахгүй байх	2 удаа	Хүнд даацын автомашины тээвэрлэлт хийх дотоод замын маршрутыг нэг урсгалаар зохион байгуулж, орох, гарах чиглэлийг тогтоон тусгаарлаж, хүдрийн овоолгын зам, баяжмал зөөх зам гэсэн чиглэлээр дотоод тээвэрлэлтийн замын маршрутыг Уурхайн даргаар батлуулан тээвэрлэлтийг зохион байгуулж байна. Мөн жолооч нарт олон салаа зам гаргахгүй байх талаар ХАБЭА-ны ажилтан тээвэрлэлт хийх бүрт зөвлөгөө өгч ажиллаж байна. <i>/Хавсралт зураг 3.4-1/</i>
2		Баяжуулах үйлдвэрийн талбайд болон ажилчдын кемп орчмын боломжит хэсэгт ногоон байгууламж бий болгох, тохижилтын ажил хийх	2 удаа	Баяжуулах үйлдвэрийн ажилчдын амрах байрны хэсэгт автомашины зогсоолын тэмдэг, зөвшөөрөлгүй машин орохыг хориглосон тэмдэг байршуулан, ажилчдын амрах байрны явган зорчих хэсгийн замыг бүхэлд нь хайрга асган тэгшилж зассан. Зуны улиралд 3 төрлийн цэцэг тарьж, усалгаа арчилгааг үйлчлэгч хариуцан ажиллаж байна. <i>/Хавсралт зураг 3.4-2/</i>
3		Түүхий эдийн тээвэрлэлтийн зам талбайг услах, хаягдлын даланд болон усалгаа хийх	Тухай бүр	Уурхайн 1, 2, 3-р амнаас баяжуулах үйлдвэрийн хүдэр буулгах талбай хүртэл замын сул шороог салхинд хийсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тоосжилт дарах усалгааг, хуурайшилт ихтэй үед 7 хоногт 1 удаа, үйл ажиллагааны туршид 4 удаагийн усалгаа хийсэн бөгөөд бөгөөд БОАЖНХЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалын 13-р хавсралтын 7-д баталсан ус хэрэглээний нормын дагуу 1 м^2 зам талбайг 2.0 л усаар усална гэсэн нормоор усны хэрэглээг тооцвол: Уурхайн талбай доторх замын урт нь 300 м буюу 3600 м^2 талбайн 1 удаагийн усалгаанд $3600 \text{ м}^2 \cdot 2.0 \text{ л} = 7.2 \text{ м}^3$ ус зарцуулагдана. 4 удаагийн усалгаанд ашигласан усны тооцоо: $7.2 \text{ м}^3 \cdot 4 \text{ хоног} = 28.8 \text{ м}^3$ ус зарцуулсан байна. <u>Төлбөрийн тооцоог ус ашиглах нормоор тооцлоо: $28.8.0 \text{ м}^3 \cdot 170.1 = 4,898.88$ төгрөг (Ус ашиглуулах дүгнэлтээс 1 м^3 усны үнэлгээг авч тооцов.)</u>

				Замын усалгаанд усны төлбөр 4,898.88 төгрөг , нийтдээ 2.4 км замыг туулж, 15 л түлш, 62,850.00 төгрөг, 2 ажилчны цалин хөлс 360000 төгрөг, бусад зардал, нийт 427,748.88 төгрөг зарцуулав. (1 хүний өдрийн дундаж цалин 90 000 төгрөг , 1 л түлш 4190 төгрөг-өөр тооцлоо // https://petrovis.mn/oron-nutgiin-shatahuunii-une) /Хавсралт зураг 3.4-3/
4		“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тариалах	500 ш 10-р сард	2025 оны 10-р сард Баяжуулах үйлдвэрийн талбайд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1500 ш хайлаас , улиас тарьж намрын цэнэг усалгааг бүрэн хийсэн. Уг ажилд нийт 15 хүн ажиллан, 7,5 сая төгрөг зарцуулав. /Хавсралт зураг 3.4-4/

3.5:Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
1	Төслийн үйл ажиллагааны үед амьтдын үүр, идэш тэжээлд сөрөг нөлөө үзүүлэх Хаягдлын даланд тэжээвэр мал амьтад орох	Амьтдын идэш тэжээл эрж хайх, зам харгуй, нүх оромжийг устахаас сэргийлэх арга хэмжээ авах	1 удаа	Баян-Овоо сумын ЗДТГазар, Хар-Ямаатын БНГ-ын хамгаалалтын захиргаа, Хар-Ямаат БНМ-ийн нөхөрлөлөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу Хар-Ямаатын БНГ болон Наран багийн Салхитад байрлах зэрлэг ан амьтдад биотехникийн арга хэмжээ авах /хужир шүү, өвс тавьж өгөх/ ажилд зориулан 1000000 төгрөгийг зарцуулан хамтран ажиллаа. /Хавсралт зураг 3.5-1/
2		Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын хэмжээг бууруулах, ургамлыг олон салаа зам гарган талхлахгүй байх	2 удаа	Уурхайн 1, 2, 3-р амнаас баяжуулах үйлдвэрийн хүдэр буулгах талбай хүртэл замын сул шороог салхинд хийсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тоосжилт дарах усалгааг хуурайшилт ихтэй үед 7 хоногт 1 удаа, үйл ажиллагааны туршид 4 удаагийн усалгаа хийж, хүдрийн овоолгын зам, баяжмал зөөх зам гэсэн чиглэлээр дотоод тээвэрлэлтийн замын маршрутыг Уурхайн даргаар батлуулан тээвэрлэлтийг зохион байгуулж, олон салаа зам гарахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна. /Хавсралт зураг 3.5-2/
3		Тэжээвэр амьтад орохоос сэргийлэн хашаа хаалт хийж бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж ажиллах, сэргээн засварлах арга хэмжээ авах	-	Уурхайн эдэлбэр газар болон Хаягдлын даланг мал амьтан орж унахаас сэргийлэн бүрэн хашаажуулсан. Хашааны бүрэн бүтэн байдалд харуул хамгаалалтын ажилтнууд хяналт тавин, засварлах ажлыг хийж гүйцэтгэж байна. Баяжуулах үйлдвэрийн урд талын 250м хашааг засаж сэлбэн, мал амьтан орохоос урьдчилан сэргийлсэн. /Хавсралт зураг 3.5-3/

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчин, геологи уул уурхайн хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, аргачлалын дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага Монгол улсын стандартын дагуу зайлшгүй хийсэн байх үүрэгтэй. 2025 оны Баяжуулах үйлдвэрийн ашиглалтын төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгөөдөөгүй.

5.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
1	Биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх, хамгаалах арга хэмжээ авах	Хэнтий аймгийн БОАЖ-ын газраас ирүүлсэн саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх	Хийж гүйцэтгэх ажлын хэмжээнээс шалтгаалан хугацаа, давтамжийг тодорхойлно.	Хэнтий аймгийн Байгаль орчны газраас ирүүлсэн саналын дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000ш нарс тарих ажилд 15 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хамтран ажиллаа. <i>/Хавсралт зураг 5-1/</i>

- Хэнтий аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2025 онд доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:
- Соёлын төвийн баруун тал /байршил 47 47 11.94, 112 06 51.55: **0.008 га** /
- ЗДТГ-ын урд талд /байршил 47 47 11.41, 112 06 55.28: **0.005 га**/
- Зуун сарнай ХХК-ийн баруун талд /байршил 47 47 07.21, 112 07 00.32: **0.01 га**/
- ЭМТ-ийн зүүн талд /байршил 47 47 16.39, 112 07 00.75: **0.02 га**/ нийт **0.043 га** газруудад үүссэн гуу жалга, замын эвдрэлд шороо болон хайрга асган тэгшилж нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэн ЗДТГ-т хүлээлгэн өгсөн. Уг ажилд 2 автомашин 4 ажилчин, түлш шатахууны зардалд **1120500 төгрөг** зарцуулсан. */Хавсралт зураг 5-2/*
- Баян-Овоо сумын хог хаягдлын цэгийг түрж цэгцлэх, мөн хог хаягдлын цэгт гарсан түймрийг унтраах ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг ажилд 1 автомашин, түлш шатахууны зардалд **1750000 төгрөг** зарцуулсан. */Хавсралт зураг 5-3/*

Дүгнэлт: 2025 оны Дүйцүүлэн хамгааллын ажилд компаниас ковш 1ш, өөрөө буулгагч автомашин 1, суудлын автомашин 1, нийт хүн оролцож, **10,370,500 төгрөг зарцуулан ажиллаа.**

6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн барилга байгууламж барих, хаягдлын далан байгуулах явцад үйлдвэрийн эзэмшлийн талбайгаас түүх, соёлын дурсгалт олдворууд илрээгүй боловч төслийн үйл ажиллагааны үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоон энэ тухай орон нутгийн Засаг дарга, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөллүүд	Ухьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
1	Ажлын байранд гарч болзошгүй гэнэтийн осол аваар	Ажилчдын амь насанд учруулж болох осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүх ажилчдыг хамгаалалтын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Хавар намрын улиралд	Баяжуулах үйлдвэрийн нийт ажилчдыг хавар, намрын нормын хөдөлмөр хамгааллын хувцсаар /хамгаалалттай гутал, гадуур хүрэм, өмд, дотуур цамц/ ханган ажиллаж байгаа бөгөөд 1 хүнд 150000 төгрөгийн хувцас хэрэгслээр нийт 18 ажилчныг 270000 төгрөгийн ХХХ-ээр хангасан. <i>/Хавсралт зураг 8-1/</i>
2		ХАБЭА-н дүрэм, замын хөдөлгөөний дүрэм, галын аюулаас хамгаалах, төлөвлөгөөг ажилчдад танилцуулж, ажил эхлэхээс өмнө аюулгүй ажлын зааварчилгаатай танилцуулах	Ажил эхлэх бүрт	Баяжуулах үйлдвэрийн 31 ажлын байрны аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулсан бөгөөд ХАБЭА-ны ажилтан ажилчдад ажил эхлэхээс өмнө өдөр тутмын зааварчилгаа өгч танилцуулан, гарын үсэг зуруулж баталгаажуулан ажилласан. <i>/Хавсралт зураг 8-2/</i>
3		Ажилчин бүр ажил эхлэхийн өмнө ажлын байр, машин, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, ажилд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, дохиолол, холбоо, гэрэлтүүлэг, хамгаалах хэрэгсэл тоноглолын гэмтэлтэй эсэхийг шалгах	Ажил эхлэх бүрт	Ажил эхлэхийн өмнө ажлын байрны аюулгүй ажиллагаа болон тоног төхөөрөмж, машин техникийн аюулгүй ажиллагааг шалгах зааврын дагуу ХАБЭА-ны ажилтан ажилчдад зааварчилгаа өгч баталгаажуулж ажилласан. Баяжуулах үйлдвэрт 5 сард 50, 6 сард 45, 7-р сард 38 хүн ажилласан байна. Гарсан зөрчилгүй хэвийн ажилласан. <i>/Хавсралт зураг 8-3/</i>
4		Эмнэлгийн анхан шатны тусламжийн хайрцагт байх эм, эмийн хэрэгсэл материалуудаар хангах	6, 9 сард 1 удаа	Баяжуулах үйлдвэрт 1ш эмийн сан 363000 төгрөгөөр авч байрлуулан, эм, хэрэгслийн нөхөн бүрдүүлэлтэд Баяжуулагч инженер хяналт тавин, шаардлагатай эм тариа, ороох боох материалаар нөхөн бүрдүүлэлт хийж, ХАБЭА-ны ажилтан ажилчдад шаардлагатай үед анхны тусламж үзүүлэн ажиллаж байна. Анхны тусламжийн эм тариа, ороох боох материал авахад нийт 250000 төгрөг зарцуулав. Нийт 613000 төгрөг зарцуулав. <i>/Хавсралт зураг 8-4/</i>

5		Бүх барилга байгууламжийн доторх цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийн угсралт монтажийг шаардагдах стандартын дагуу хийж, тогтмол үзлэг шалгалт хийх	Үйл ажиллагааны туршид сард 1 удаа	Баяжуулах үйлдвэрийн дотоод цахилгаан сүлжээний холболтын бүрэн бүтэн байдлыг үйлдвэрийн цахилгаанчин байнгын хяналт тавин ажиллаж, шаардлагатай үед засвар үйлчилгээг хийж гүйцэтгэж байна. Цахилгаан сүлжээнд 2 удаа гэмтэл гарч, Багануурын ЗБЦТГ-т хүсэлт тавьж тухай бүр гэмтлийг засуулж ажилласан.
6	Хээрийн болон объектын гал түймэр	Хээрийн болон объектийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх болзошгүй аюул осол тохиолдоход гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг бэлэн байлгах, нөхөн бүрдүүлэлт хийх	8 сард 1 удаа	Баяжуулах үйлдвэрийн хэмжээнд гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн сарайг бүх барилга байгууламжийн гадна талд байрлуулан, багаж хэрэгслийн нөхөн бүрдүүлэлтийн хангалтыг байнга хийж ирсэн. Уурхайн хэмжээнд гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр бүрэн хангагдсан. Мөн баяжуулах үйлдвэрт 2ш галын дохиолол байрлуулсан. Шинээр галын хор 2ш, 180000 төгрөг, самбар 1ш, 48000 төгрөг, уг ажилд нийт 750000 төгрөг зарцуулсан. /Хавсралт зураг 8-6/
7		Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх самбарыг баяжуулах үйлдвэрийн цех хэсгүүдэд байршуулах, галын хорны хяналтын карт хөтлөх, галын хорны тэмдэг тэмдэглээгээг шинэчлэх	8 сард 1 удаа	Баяжуулах үйлдвэр болон засварын цехүүдэд байрлуулсан гал унтраагуурын хэвийн ажиллагааг шалган тэмдэглэх пайзыг гал унтраагуурт зүүж, сар бүр хяналт хийн тэмдэглэж байгаа бөгөөд гар унтраагуур байрлуулсан газарт галын хорны тэмдэг тэмдэглэгээ бүрэн байрлуулсан. Тайлангийн хугацаанд галын хорны пайз 30ш-ийг 99000 төгрөгөөр захиалан авч шинэчилсэн. /Хавсралт зураг 8-7,8/
8	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах үйл ажиллагааны горим алдагдсанаас байгаль орчин бохирдох, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Химийн бодис хадгалах агуулах, шинжилгээний өрөөнд галын хорыг стандартын дагуу байршуулах	8 сард 1 удаа	Шинжилгээний өрөөнд 5л-ийн нунтаг галын хор 1ш, агуулахад 10л-ийн нунтаг галын хор 2ш-ийг 297000 төгрөгөөр авч стандартын дагуу байрлуулсан. /Хавсралт зураг 8-7,8/
9		Химийн бодисын аюулгүй ажиллагааны самбар, тэмдэг тэмдэглэгээг шинээр хийлгэж байршуулах	8 сард 1 удаа	Баяжуулах үйлдвэрийн химийн бодис найруулах хэсэгт 2 ш самбар, шинжилгээний өрөөнд химийн бодисын аюулгүй ажиллагааны самбар 1ш-ийг нүдэнд харагдахуйц газар байрлуулсан. Нийт 3ш самбар, 132000 төгрөг зарцуулсан. /Хавсралт зураг 8-9/
10		Химийн бодис хадгалах агуулахуудыг засварлаж, стандартын дагуу тохижуулах /агуулах нь тухайн бодисын ХАЛМ-д заасан шингээгч материалаар /зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч гэх.мэт/ хангагдсан байна/	8 сард 1 удаа	Химийн бодис хадгалах агуулахын дээврийн засвар хийж, борооны ус орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авав. 2 агуулахад хадгалагдаж буй химийн бодисуудыг стандартын дагуу тусгаарлалт хийж, зориулалтын дагуу хадгалж байгаа бөгөөд шаардлагатай үед холбоо барих ажилчдын утасны дугаар, химийн бодисын ХАЛМ, хаяг зэргийг шинээр байрлуулан тохижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. /Хавсралт зураг 8-10/
11		Химийн хорт бодистой харьцах үеийн өдөр тутмын зааварчилгааг батлуулж, цех хэсгүүдэд байршуулах	6 сард 1 удаа	Баяжуулах үйлдвэрийн химийн бодис найруулах хэсэг, шинжилгээний өрөө, химийн бодис хадгалах агуулахуудад химийн бодистой харьцах

				өдөр тутмын зааварчилгааг шинээр боловсруулан нүдэнд ил харагдахуйц газар байрлуулан ажиллаж байна. <i>/Хавсралт зураг 8-11/</i>
12		Химийн бодисын зарцуулалтын бүртгэлийг тухай бүр хөтлөх, зарцуулалтын тайланг хугацаанд нь гаргах, дээд байгууллагад тайланг хүргүүлэх	Үйлдвэр ажиллах үед 11 сард 1 удаа	Химийн бодисын зарцуулалтын бүртгэлийг Баяжуулах үйлдвэрийн баяжуулалтын инженер үйл ажиллагаа явуулж буй үед өдөр тутам хөтөлдөг. 2025 оны 6-р сард Хэнтий аймгийн Тагнуулын газарт химийн бодисын орлого, зарлага, үлдэгдлийн тайланг гаргаж өгсөн. Байгаль орчны газарт гаргаж өгөх тайлангийн хугацаа болоогүй байна.
13		Үйлдвэрт хэрэглэгдэж буй химийн бодисын хор аюулгүйн лавлах мэдээллийг бодис бүрээр шинэчлэн хийж нүдэнд ил харагдахуйц байршуулах /ажилтан нэг бүр тухайн бодис, хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх арга зэргийг сайтар уншиж танилцан мөрдөх/	7 сард 1 удаа	Баяжуулах үйлдвэрийн технологит 3 төрлийн химийн бодис, шинжилгээнд зөвшөөрөл авсан 15 бодисоос 5 төрлийн бодисыг ашиглаж байгаа бөгөөд нийт 8 төрлийн химийн бодисын ХАЛМ-ийг боловсруулан, баяжуулах үйлдвэр болон шинжилгээний өрөөнд нүдэнд ил харагдахуйц газар байршуулан ажиллаж байна. <i>/Хавсралт зураг 8-13/</i>
14	Үер усны аюул	Гэнэтийн үер усны аюулаас урьдчилан сэргийлэн үерийн далан хийж суваг шуудуу татах, бүрэн бүтэн байдлыг хянах	8 сард 1 удаа	Уурхайн эдэлбэр газрын хашаа хайсны гадна талаар үес уснаас сэргийлэн суваг шуудуу татсан бөгөөд доош суулт үүссэн тохиолдолд сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн. <i>/Хавсралт зураг 8-14/</i>
15	Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг ШТС болон ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газарт сурилуулах, цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, холбогдох байгууллагаар ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулах	7 сард 1 удаа	Шатахуун хадгалах түр агуулах болон тэсрэх бодисын агуулах нь аянга зайлуулагчтай газардуулгын хэмжилтийг хуулийн хугацаанд хийлгэж хэвшсэн. Мөн уурхай болон баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжуудад галын аюулгүй байдлын дүгнэлтийг бүрэн авсан бөгөөд нийт 4 барилга байгууламжийн галын аюулгүй байдлын дүгнэлттэй, тухай бүр хугацааг сунгуулсан. <i>/Хавсралт зураг 8-15/</i>

9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
1	Цаасны хаягдал	Оффисоос гарч буй цаасны хаягдлыг (бүх төрлийн цаасан хайрцаг, бусад)	Тухай бүр	Уурхай болон баяжуулах үйлдвэрийн хог хаягдал түр хадгалах цэгт цаасны хаягдал болон хүнсний хаягдлыг ангилан хаях сав байрлуулан

		зориулалтын хогны уутанд ангилан хаях		зориулалтын хогийн уутанд савлан хуримтлуулж Баян-Овоо сумын Хог хаягдлын нэгдсэн цэгт хуримтлал үүсэх бүрт тээвэрлэн хаяж байна. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны хугацаанд 25тн-ын даацтай өөрөө буулгагч автомашинаар 2 удаа, нийт 50тн хог хаягдлыг тээвэрлэж хаясан. Шатахууны зардалд нийт 50л түлш зарцуулж, 4 ажилтан ажилласан. <i>/Хавсралт зураг 9-1/</i>
2	Хуванцар хаягдал	Уурхайн кемпээс үүсэж болох хуванцар сав баглаа боодлыг (цэвэр ус, ундаа, хоолны хуванцар сав ундааны лааз, тугалган сав гэх мэт) савыг суллан зориулалтын газарт цуглуулж эргүүлэн ашиглах шаардлагатай газарт нийлүүлэх	Тухай бүр	Баяжуулах үйлдвэрийн кемпийн ашиглалтаас гарч буй хуванцар сав баглаа боодлыг 3х3 9м² талбай бүхий ангилан хаях торон хашаа хийж, ангилан хадгалж байна. Тайлангийн хугацаанд тээвэрлэлт хийгдээгүй. <i>/Хавсралт зураг 9-2/</i>
3	Бусад	Хатуу хог хаягдлыг хөрсөнд элдэв шингэн нэвчиж бохирдуулахааргүй, салхинд хийсч орчныг бохирдуулахааргүй тусгайлсан төмөр торон хашлагад байршуулах, хатуу хаягдал цуглуулах байгууламж хийх	1 удаа	Уурхай болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарч буй хатуу хог хаягдлыг тусгай талбайд төвлөрүүлэн хадгалж байна. <i>/Хавсралт зураг 9-3/</i>
4		Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж хогийн сав байршуулах (ажилчдын байрны ойролцоо болон дотор орчинд)	3	Баяжуулах үйлдвэрийн ажилчдын кемпийн орчинд болон амрах байранд ахуйн хэрэглээнээс гарч буй хог хаягдлаа ангилан хаях 2 төрлийн хогийн сав байрлуулан хог хаягдлаа ил задгай хаяхаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Гадна орчинд 2 төрлийн ангилан хаях сав 2ш, ажилчдын амрах байранд 12ш, нийт 14ш хог хаягдал ангилан хаях сав байршуулан, 420000 төгрөг зарцуулав. <i>/Хавсралт зураг 9-4/</i>
5		Дахин боловсруулагдахгүй бусад хаягдлыг (хоолны хаягдал, норсон, дахин ашиглах боломжгүй хаягдал, 00-н цаас) зориулалтын хогийн цэгт хаях	Тухай бүр	Уурхайн хог хаягдал түр хадгалах цэгт дахин боловсруулагдахгүй бусад хаягдлыг хадгалж байна.
6	Төмрийн хаягдал	Төмрийн хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт нийлүүлэх	Тухай бүр	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсч буй төмрийн хаягдлыг хатуу хог хаягдал үүсэх талбайд төрөлжүүлэн хадгалж байна. Тайлангийн хугацаанд тээвэрлэлт хийгдээгүй.
7	Модны хаягдал	Модны хаягдлыг ахуйн түлшинд хэрэглэх	Тухай бүр	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд модон материал ашиглаагүй тул модны хаягдал үүсээгүй байна.
8	Аюултай хог хаягдал	Уурхайн үйл ажиллагааны явцад гарсан хоёрдогч түүхий эдийн хог хаягдлыг ангилан ялган тусгай цэгт	Тухай бүр	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй хүнд даацын автомашины засвар үйлчилгээнээс гарсан тос тосолгооны үлдэгдэлийг баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд

		цуглуулж, төвлөрсөн цэгт тушаах, ШТМ-ын хаягдлыг хуримтлуулан хаягдал авах газарт (Алтан оршихуй ХХК, 99104569) хүргүүлэх		ашигладаг тул хаягдал үүсээгүй байна. ШТМ-ын хаягдлыг аюултай хог хаягдлын сав баглаа боодолтой хамт хадгалж байна. <i>/Хавсралт зураг 9-8/</i>
9		Аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг (гутал, химийн бодист тэсвэртэй хамгаалалтын хувцас, малгай, нүдний шил, бээлий, нүүрний баг, амьсгал хамгаалах баг) шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангах	1 удаа	Химийн бодистой харьцаж буй 3 ажилчныг хамгаалалтын хувцсаар бүрэн ханган ажиллаж байна. Химийн бодисоос хамгаалах комбинзон 3ш, маск 9ш, нүдний шил 3ш, хамгаалалтын резинэн хамгаалалтын бээлийн 12ш, нийт 270000 төгрөг зарцуулав.
10	Бусад	Ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт цуглуулан тээвэрлэхдээ сумын захиргаатай гэрээ байгуулж ажиллах	1 удаа	Баяжуулах үйлдвэрээс үүсч буй ахуйн хог хаягдлыг түр хадгалах цэгт төвлөрүүлэн хадгалж, Баян-Овоо сумтай 2025.06.06-ны өдөр Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Хог хаягдлын 1-3-р улирлын төлбөр болох 2700000 төгрөгийг төсөвт төвлөрүүлээд байна. <i>/Хавсралт зураг 9-10/</i>
11		Хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаж байх	2 удаа	Баяжуулах үйлдвэрийн ахуйн хог хаягдал хадгалах түр цэгийн ойр орчмын ариутгал, цэвэрлэгээг үйлчилгээний ажилчид хариуцаж 7 хоногтоо 1 удаа их цэвэрлэгээ хийж хэвшсэн. Үйлчилгээний ажилчдыг 7 хоног бүр цэвэрлэгээний хэрэгсэл болон ариутгалын бодис, багаж хэрэгслээр ханган, ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Ариутгалын бодис болон багаж хэрэгсэлд нийт 310000 төгрөг зарцуулав.
12		Нийтийн цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа зохион байгуулах	8 удаа	Баяжуулах үйлдвэрийн нийт ажилчид ээлж хүлээлцэх бүрт орчны хог хаягдлын их цэвэрлэгээг тогтмол хийж ажлаа хүлээлцэж хэвшсэн. Кемпийн үйлчлэгч болон туслах ажилчид кемп орчмын цэвэрлэгээ болон ойр орчмын хог хаягдлыг сард 1 удаа, нийт 8 удаа цэвэрлэсэн. Уурхай болон баяжуулах үйлдвэрийн нийт ажилчдын бүх нийтийн цэвэрлэгээг 5, 9 саруудад 2 удаа зохион байгуулж модны нүхэнд хуримтлагдсан хог хаягдал, ойр орчны хог хаягдал зэргийг цэвэрлүүлж, нийт давхардсан тоогоор 46 ажилчид хамрагдсан. <i>/Хавсралт зураг 9-12/</i>

**10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
Агаарын чанар				
1	Агаар орчны шинжилгээг мэргэжлийн байгууллагын шинжээчээр хийлгэх	Агаарын бохирдол: Нүүрстөрөгчийн исэл СО Азотын исэл (NO ₂) Хүхрийн давхар исэл (SO ₂), -Ажилчдын кемп -Хаягдлын далан орчинд -Баяжуулах үйлдвэр	5, 9 сард 3 цэг	ОХШХ-т тусгагдсанаар нийт 3 цэгээс 2 удаа хүхэрлэг хий (SO ₂), азотын давхар исэл NO ₂ , нийт тоос 3 цэгээс 2 удаа шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүнгийн тоон үзүүлэлтийг стандарттай харьцуулан гаргалаа. <i>Тоон үзүүлэлтүүдийг Хүснэгт 1-ээс харна уу.</i> <i>/Хавсралт зураг 10-1,2/</i>
2	Тоосжилт Нийт тоос (PM2.5, PM10)	CO, SO ₂ , NO ₂ -Хаягдлын далан, -Дотоод тээврийн зам -ажилчдын тосгон -баяжуулах үйлдвэр	5, 9 сард 4 цэг	Баяжуулах үйлдвэрийн агаарын орчны шинжилгээг ОХШХ-т заасны дагуу агаарын чанар 3 цэгт, 2 удаа, тоосонцор 4 цэгт 2 удаа хэмжилт хийлгэж, шинжилгээний үр дүнгээр ЗДТ-ээс доогуур буюу агаарын бохирдол үсээгүй, мөн тоосонцор стандартын хүлцэх хэмжээнээс хэтрээгүй байна. <i>Тоон үзүүлэлтүүдийг хүснэгт 1-ээс харна уу.</i> <i>/Хавсралт зураг 10-1,2/</i>
3	Гадаад болон дотоод орчны дуу чимээний түвшин	-Машин механизмын хөдөлгөөн -Үйлдвэрийн бүх цех, хэсгүүдэд -Захиргаа, аж ахуйн байр -Шинжилгээний өрөө	Сард 1 удаа 4 цэг	Дуу шуугианы хэмжилтийг 4 цэг дээр 3 удаагийн давтамжтайгаар хэмжилт хийж, хэмжилтийн ерөнхий дундаж утгаар хүснэгтээр үр дүнг гаргав. Шинжилгээ хийх үед баяжуулах үйлдвэрийн бутлуурын хэсэг ажиллаж байсан тул дуу чимээ баяжуулах үйлдвэрийн орчин, машин механизмын хөдөлгөөний үед стандартын ЗДХ-ээс давсан үзүүлэлттэй гарсан байна. <i>Тоон үзүүлэлтийг Хүснэгт 2-оос харна уу.</i>
Хөрсний бохирдол				
4	Хөрсний металлууд ICP-28	-Хаягдлын далан -шимт хөрсний овоолго -ажилчдын тосгон	8 сард 3 цэг	Хөрсний хүнд металлын шинжилгээ буюу хөрсний бохирдлыг тодорхойлох зорилгоор 2 удаагийн давтамжтайгаар нийт 3 цэгээс шинжилгээ авч Хэнтий аймгийн УЦУОШГын итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэн дүгнэлтийг тайланд хавсаргав. Нийт 28 төрлийн бодисын шинжилгээ хийгдсэн бөгөөд шинжилгээний үр дүнгээс баяжуулах үйлдвэрийн орчим, үйлдвэрийн хаягдал орчимд (MNS 5850:2019)-ийн стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна. <i>/Хавсралт зураг 10-4,5/</i>

5	Ялзмаг %, pH, CaCO ₃ , EC _{2.5} , Хөдөлгөөнт фосфор, кали, механик бүрэлдэхүүн, эзэлхүүн, жин	- Хаягдлын далан орчинд - Ажилчдын кемп орчинд	5, 9 сард 2 цэг	Хөрсний ерөнхий үзүүлэлтийн шинжилгээг ОХШХ-т тусгагдсанаар 2 цэгээс дээж авч Хэнтий аймгий УЦОШГ-ын итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэн шинжилгээний дүнг тайланд хавсаргав. <i>Тоон үзүүлэлтийг Хүснэгт 3-аас харна уу.</i> <i>/Хавсралт зураг 10-4,5/</i>
Усны хяналт шинжилгээ				
6	Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага	Гүний худаг 111°47'13" 47°44'16 (Анионууд: Cl ⁻ , SO ₄ ⁻ , NO ₂ ⁻ , NO ₃ ⁻ , CO ₃ ⁻ , HCO ₃ ⁻ Катионууд: Na ⁺⁺ K ⁺ , Ca ⁺⁺ , Mg ⁺⁺ , NH ₄ ⁺ , Fe ⁺⁺ , Fe ⁺⁺⁺ , pH, EC, TDS, Физик чанар: тунгалаг, үнэр, тунадас, өнгө, амт)	5, 9 сард 2 цэг	ОХШХ-т тусгагдсаны дагуу баяжуулах үйлдвэрийн ажилчдын унд ахуйн усны дээжийг уурхайн ашиглалтын талбайд гаргасан 1 гүн өрмийн худаг болон уурхайд ойрхон нутагладаг малчны худгаас /фон цэг/ 2 удаа дээж авсан бөгөөд дээжийн химийн ерөнхий шинжилгээг Хэнтий аймгийн УЦОШГ-ын ИТГЭМЖЛЭГДСЭН лабораторид шинжлүүлэв. Усны шинжилгээний үр дүнг MNS 0900:2018 (Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт) стандарттай харьцуулав. <i>/Хавсралт зураг 10-6/</i>
7	Усан дахь нян бактерийн шинжилгээ	-Гүн өрмийн худаг 111°47'13" 47°44'16	7 сард 1 цэг	Дээж хийгдээгүй
8	Хаягдал усны химийн найрлагын шинжилгээ /Al, Cd, Cr, Cu, Fe, Mn, Mo, Pb, As, Hg, WAD, CN, Ni, Ag, Zn/	-Хаягдлын ус //баяжуулах үйлдвэрийн хаягдал ус/	6, 9 сард 1 цэг	Хаягдал усны дээжийг Байгаль орчны мэргэжилтэн 10-р сард авч Усны газрын харъяа Байгаль орчны шинжилгээний лабораторид хүргүүлсэн. Дээжний хариу тайлангийн хугацаанд гараагүй байна. <i>/Хавсралт зураг 10-8/</i>
Ургамлан нөмрөг				
9	-Ургамлын зүйлийн бүрдэл, -тусгаг бүрхэц, -арвийн үнэлгээ	Уурхайн талбайн ойр орчмын	8 сард 2 цэг	Уурхай болон баяжуулах үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох зорилгоор ашиглалтын талбайн ойр орчмын 2 цэгт ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, тусгаг бүрхэц зэргийн судалгааг хийж дүгнэлт гаргалаа. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг гаргахдаа 1м*1м ашиглан тодорхойлсон. Тусгаг бүрхэцийн хувийг нүдэн баримжаагаар халцгай газрын эзлэх хувиар илэрхийлэв. <i>Тоон үзүүлэлтийг тайлангийн 24-р хуудаснаас харна уу.</i> <i>/Хавсралт зураг 10-9/</i>
Амьтны аймаг				

10	Амьтны зүйлийн бүрдэл, тархалт байршлын судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгөх	Төслийн талбай болон түүний ойр орчинд	8 сард 2 цэг	ОХШХ-т тусгагдсаны дагуу баяжуулах үйлдвэрийн талбайн орчинд болон талбайгаас баруун тийш 200м хүртэл газарт ан амьтдын тархалтын ажиглалт хийхэд зэрлэг ан амьтад тааралдаагүй бөгөөд үлийн цагаан оготны нүх оромж талбайн гадна талд цөөн тоогоор тархсан байна.
----	---	--	-----------------	---

Агаарын орчны шинжилгээг Мэргэжлийн байгууллагын шинжээчээр хийлгэх:

Агаарын чанарын хяналт шинжилгээг 2025 оны 5-р, 8-р сард Хэнтий аймгийн УЦОШГ-тай гэрээ байгуулан, шинжилгээний баг ирж газар дээр нь хэмжилтүүдийг хийж ЦУОШТөвийн БОХЗТЛ-иор **MNS 4585:2016** стандартын дагуу шинжлүүлж шинжилгээний дүгнэлтийг гаргууллаа.

ОХШХ-т тусгагдсанаар нийт 3 цэгээс 2 удаа хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл NO_2 , нийт тоос 4 цэгээс 2 удаа шинжилгээ хийлгэсэн. Хүснэгтэд шинжилгээний үр дүнгийн тоон үзүүлэлтийг стандарттай харьцуулан гаргалаа.

Хүснэгт 1. Төслийн талбайн агаарын бохирдлын хэмжилтийн үр дүн, мг/м^3

Хүснэгт 1: Хөдлийн татлагын агаарын бохирдол хэмжээний үр дүн, мс

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	TSP	Дуу чимээ
				мг/м³			дБА
1	Баяжуулах үйлдвэр	VI/16	09:40	0.015	0.087	0.049	75
		IX/15		0,023	0,032	0,054	
3	Ажилчдын кемп орчимд	VI/16	11:20	0.002	0.017	0.043	59
		IX/15		0,016	0,079	0,035	
4	Дотоод тээврийн зам	VI/16	10:55	0.008	0.031	0.047	64
		IX/15		0,010	0,035	0,049	
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 /20 минутын хэмжилт/				0.450	0.200		
ХАБЭМ. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015				-	-	0,150	-
ХАБЭМ. Шүүгианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000				/8 цагийн хэмжилт/			85

Дүгнэлт: Баяжуулах үйлдвэрийн агаарын орчны шинжилгээг ОХШХ-т заасны дагуу агаарын чанар 34 цэгт, 2 удаа, тоосонцор 4 цэгт 2 удаа хэмжилт хийлгэж, шинжилгээний үр дүнгээр ЗДТ-ээс доогуур буюу агаарын бохирдол үссэгүй, мөн тоосонцор стандартын хүлцэх хэмжээнээс хэтрээгүй байна.

Дуу шуугиан, чичиргээ:

Дуу, шуугианы хэмжилт: Дуу шуугианы хэмжилтийг 4 цэг дээр 3 удаагийн давтамжтайгаар хэмжилт хийж, хэмжилтийн ерөнхий дундаж утгаар хүснэгтэд үр дүнг гаргав. Шинжилгээ хийх үед баяжуулах үйлдвэрийн бутлуурын хэсэг ажиллаж байсан тул дуу чимээ баяжуулах үйлдвэрийн орчин, машин механизмын хөдөлгөөний үед стандартын ЗДХ-ээс давсан үзүүлэлттэй гарсан байна.

Хүснэгт 2. Дуу шуугианы хэмжилтийн дүн, дБА

№	Байрлал	Багажаар хэмжсэн үзүүлэлт			Гар утасны аппаар хэмжсэн үзүүлэлт		
		Min	Max	Avg	Min	Max	Avg

1	Үйлдвэрийн бүх цех хэсгүүд	81	82	81	41	102	72
2	Шинжилгээний өрөө	72	79	75	41	82	52
3	Ажилчдын кемп орчим	42	84	68	45	72	50
4	Машин механизмын хөдөлгөөн	84	84	84	53	93	75
MNS 4585:2016 /орон байрны доторхи /		Өдрийн цаг (07-22) 60 Шөнийн цаг (22-07) 45					
Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл мэнд. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000					85		

Хөрсний чанарын хяналт шинжилгээ: Хөрсний хүнд металлын шинжилгээ: Хөрсний хүнд металлын шинжилгээ буюу хөрсний бохирдлыг тодорхойлох зорилгоор 2 удаагийн давтамжтайгаар нийт 4 цэгээс шинжилгээ авч Хэнтий аймгийн УЦОШГ-ын итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэн дүгнэлтийг тайланд хавсаргав. Нийт 28 төрлийн бодисын шинжилгээ хийгдсэн бөгөөд шинжилгээний үр дүнгээс баяжуулах үйлдвэрийн орчим, үйлдвэрийн хаягдал орчимд (MNS 5850:2019)-ийн стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.

Хөрсний ерөнхий шинжилгээ: Хөрсний ерөнхий үзүүлэлтийн шинжилгээг ОХШХ-т тусгагдсанаар 2 цэгээс дээж авч Хэнтий аймгий УЦОШГ-ын итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэн шинжилгээний дүнг тайланд хавсаргав.

Хөрсний химийн үзүүлэлтүүд:

Хүснэгт 3. Дээжинд хийсэн химийн үзүүлэлт

Цэгийн нэр	Огноо	pH	Чийг %	Аммиак NH ₄ мг/л	Ялзмаг %	Сульфат SO ₄ мг/л	Нитрат NO ₃ , мг/л	Фосфор P ₂ O ₅
Ажилчдын кемп	VI/16	8.47	1.11	33.60	0.93	17.27	119.55	3.75
	IX/15	8.92	1.1	31.85	5.13	179.3	20.13	31.75
Баяжуулах үйлдвэр	VI/16	8.84	1.06	14.11	2.16	22.19	3.05	17.03
	IX/15	7.84	1.66	17.13	3.16	32.16	2.15	19.07

Усны чанарын хяналт шинжилгээ:

Усны чанар pH, ууссан нийт давс (эжингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ:

ОХШХ-т тусгагдсаны дагуу баяжуулах үйлдвэрийн ажилчдын унд ахуйн усны дээжийг уурхайн ашиглалтын талбайд гаргасан 1 гүн өрмийн худаг болон уурхайд ойрхон нутагладаг малчны худгаас /фон цэг/ 2 удаа дээж авсан бөгөөд дээжийн химийн ерөнхий шинжилгээг Хэнтий аймгийн УЦОШГ-ын

ИТГЭМЖЛЭГДСЭН лабораторид шинжлүүлэв. Усны шинжилгээний үр дүнг **MNS 0900:2018** (Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт) стандарттай харьцуулав.

Ургамлын зүйлийн бүрдэл, тусгаг бүрхэц, арвийн үнэлгээ:

Уурхай болон баяжуулах үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох зорилгоор ашиглалтын талбайн ойр орчмын 2 цэгт ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, тусгаг бүрхэц зэргийн судалгааг хийж дүгнэлт гаргалаа. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг гаргахдаа 1м*1м ашиглан тодорхойлсон. Тусгаг бүрхэцийн хувийг нүдэн баримжаагаар халцгай газрын эзлэх хувиар илэрхийлэв. Ургамлын судалгааг доорх байдлаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✚ Ургамлын оройн болон суурийн бүрхэвчийн харьцуулалт: Энэ нь тухайн жилийн ургамлын гарцтай шууд холбоотой. Хагд өвсний хуримтлалаас тухайн жилийн ургацын байдалд цэг тус бүрээр дүгнэлт хийх
- ✚ Ургамал хоорондын зайг нүдэн баримжаагаар тодорхойлох: Энэ нь хөрс салхиар хийсэх, усанд урсах, хог ургамал түрж ургах орчныг бүрдүүлэх, хөрсний усны ууршилт явагдах гол хүчин зүйл болдог.
- ✚ 2 цэг тус бүрийн ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц /хагд болон сөөгөн/ болон нэгж талбайн зүйлийн тоо зэргийг гаргасан бөгөөд судалгааны талбайн зайнаас хамааран уурхайтай ойрхон буюу доройтолд өртөх магадлал өндөртэй 1 талбайг фон цэгээр авч судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Ургамлын судалгаа хийсэн цэг				
№	Цэгүүдийн байршлын нэр	Уртраг	Өргөрөг	Өндөршил
1	Баяжуулах үйлдвэрийн орчинд	111 47 13.88	47 44 24.13	1127 м
2	Хаягдлын далангаас баруун тийш 250 м-т фон фэг	111 46 47.34	47 44 26.87	1127 м

Ургамлын судалгааны үр дүн:

1-р цэг: Ургамлын бүрхэцийн өндөр 5.5-30см, ургамал хоорондын зай 2-15см, хагд өвсний хуримтлал бага зэрэг, хөрс салхиар хийсч ургамлын үндэс ил гарсан, өнгөн хөрс жижиг чулуутай хайргархаг болсон байна. Зүйлийн тоо 9, үетэн 4, алаг өвс 2, сонгинолог 2, шарилж 1

2-р цэг: Ургамлын бүрхэцийн өндөр 3-30см, ургамал хоорондын зай 5-45см, хагд өвсний хуримтлал байхгүй, хөрс усанд урсч ургамлын үндэс шороонд дарагдсан, өнгөн хөрсөнд жижиг чулуу ил гарсан, элсэрхэг болсон байна. Зүйлийн тоо 4, үетэн 2, шарилж 1, алаг өвс 1

Амьтны зүйлийн бүрдэл, тархалт байршлын судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгөх

- ✚ ОХШХ-т тусгагдсаны дагуу баяжуулах үйлдвэрийн талбайн орчинд болон талбайгаас баруун тийш 200м хүртэл газарт ан амьтдын тархалтын ажиглалт хийхэд зэрлэг ан амьтад тааралдаагүй бөгөөд үлийн цагаан оготны нүх оромж талбайн гадна талд цөөн тоогоор тархсан байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ОХШХ-т тусгагдсан агаар орчны шинжилгээ, хөрсний бохирдол, усны хяналт шинжилгээ, ургамал, амьтны судалгаа зэрэг төлөвлөгдсөн ажлууд бүрэн хийгдсэн бөгөөд ОХШХ-т нийт 30170000 төгрөг зарцуулав.

11.ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
1	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэнг захирлын тушаалаар томилох, байгаль орчны асуудлыг хариуцан ажиллах	-	2024 оны 2-р сараас эхлэн Байгаль орчны мэргэжилтэн томилон ажиллуулж байна.
2	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах	6 сар	Баяжуулах үйлдвэрийн 2025 оны БОМТ-г 6-р сард БОУАӨЯ-ны ХБОБЗГ-ын ахдах шинжээч З.Цогтбаяраар батлуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллаа. <i>/Хавсралт зураг 11-2/</i>
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг тухайн жилийн 10 дугаар сарын 31 ний дотор БОУАӨЯаманд хүргүүлэх	10 сар	Баяжуулах үйлдвэрийн 2025 оны БОМТ-ний тайланг БОУАӨЯ-ний еис.mn мэдээллийн санд хуулийн хугацаанд байршуулан Хэнтий аймгийн Байгаль орчны газарт тайлан хүлээж авах комисс ажиллуулах хүсэлтийг 2025.10.30-ны өдрийн 84/25 тоот албан тоотоор хүргүүлсэн. <i>/Хавсралт зураг 11-3/</i>
4	Болзошгүй аюул ослын үед ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах	7 сар	Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг Хэнтий аймгийн Баян-Овоо сумын ЭМТ-тэй хамтран зохион байгуулж, ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулав. <i>/Хавсралт зураг 11-4/</i>
5	Өвөлжилт хүндэрсэн үед нутгийн иргэдэд өвс, хадлангийн тусламж үзүүлэх	Санал хүсэлтийн дагуу	Сумын Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн дагуу сумын төвийн 4-р багт бохирын цооног хальж урсан хөрсний бохирдол үүсэн, иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсэн тул бохир соруулах автомашины сэлбэг хэрэгслийг авахад 7502500 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. <i>/Хавсралт зураг 11-5/</i>
6	Орон нутгийн иргэдийг дэмжих зорилгоор шаардлагатай хүнсийг иргэдээс худалдан авах	Тухай бүр	Баян-Овоо сумын худалдаа үйлчилгээ явуулдаг ААН-үүд болон нөлөөллийн бүсэд амьдардаг малчидтай хоол хүнсээр хангах аман хэлэлцээр хийж жил бүр хамтран ажилладаг.
7	БО-г хамгаалах, ХАБЭА, ШТМ-ын асгаралт, хадгалалт, ашиглалт, устгалын чиглэлээр өөрийн ажилтан, ажилчдын дунд сургалт зохион байгуулах, өдөр тутамд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	6 сард	ХАБЭА-ны ажилтан ажилчдад ажлын байр бүрээр өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулан баталгаажуулж ажиллсан. Баяжуулах үйлдвэрийн 2025 оны ХАБЭА-ны сургалтын төлөвлөгөөний дагуу Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, тавигдах шаардлага, галын аюулаас урьдчилан сэргийлэх, Хувийн хамгаалах хэрэгсэл, хэрэглээ сэдвүүдээр сургалт зохион байгуулж, сургалтад нийт давхардсан тоогоор 28 ажилчид хамрагдсан. <i>/Хавсралт зураг 11-7/</i>
8	Орон нутгийн удирдлага болон иргэдэд төслийн үйл ажиллагааны биелэлт, байгаль орчныг хамгаалах, орчны хяналт	БИНХ зарлагдах үед	Сум орон нутаг, багаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд тогтмол оролцож, уурхайн үйл ажиллагаагаа танилцуулах, БОМТ-нд

	шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаар танилцуулга, хэлэлцүүлгийг хийж байх		тусгуулах санал хүсэлтийг бичгээр болон БИНХ-д гарсан санал хүсэлтийг хүлээн авч үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.
9	Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчны аудитыг 2 жил тутамд 1 удаа хийлгэх ¹	2 жилд 1 удаа	Уурхай болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд 2023 онд Баягаль орчны аудитын мэргэжлийн байгууллага болох “ЭБГ Консалтинг” ХХК-иар байгаль орчны аудитыг хийлгэсэн. <i>/Хавсралт зураг 11-9/</i>
10	Төслийн үйл ажиллагааны явцад газрын төлөв байдал чанарын хянан баталгааг 5 жил тутамд 1 удаа хийлгэх	5 жилд 1 удаа	2025 онд Уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг Мэргэжлийн байгууллагаар 8 сая төгрөгөөр хийлгэж дүгнэлт гаргуулсан. <i>/Хавсралт зураг 11-10/</i>

12.ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
1	Хэнтий аймгийн Баян-Овоо сумын багийн ИНХ	Сумын багийн ИНХ-аар илтгэл тавьж мэдээлэл өгөх	БИНХ-ын тов зарласан үед	Сум орон нутаг, багаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд тогтмол оролцож, уурхайн үйл ажиллагаагаа танилцуулах, БОМТ-нд тусгуулах санал хүсэлтийг бичгээр болон БИНХ-д гарсан санал хүсэлтийг хүлээн авч үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.
2	Аймгийн БО-ны газар	БОМТ биелэлтийн тайланг тайлан хэлбэрээр хүргүүлэх, биелэлтийн тайлан дүгнэх ажлын хэсгийн хамт газар дээр нь танилцуулах	Хуулийн хугацаанд 11-р сарын 1	БОМТ-ний тайланг ажлын хэсгээр дүгнүүлэх хүсэлтийг Хэнтий аймгийн БГазарт Захирлын 2025 оны 10-р сарын 30-ны өдрийн 84/25 тоот албан тоотыг khentiinature@gmail.com цахим хаягаар илгээсэн.
3	БОУАӨЯам	БО-г хамгаалах ажлын жилийн тайлан, төлөвлөгөө БОУАӨЯ –нд цаг тухайд нь гаргаж өгч байх	12 сард	Хугацаа болоогүй

¹ Ерөнхий үнэлгээний дүгнэлт Онцгойлон анхаарах зүйлс /9/